54

МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК
Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2024.09.06 № А-1/680

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Таны 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн, эрх бүхий байгууллагаас тодорхой байгууллага, аж ахуйн нэгжийн дансыг битүүмжлэх үйл ажиллагаатай холбоотой Монголбанканд тавьсан асуулгатай танилцлаа.

Монгол Улсад иргэн хуулийн этгээдийн банкан дахь дансны гүйлгээг битүүмжлэх үйл ажиллагааг хуульд заасны дагуу шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, прокурор, татварын албаны үйл ажиллагаа, бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх зохицуулалттай.

Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр шүүгч битүүмжлэх эрхтэй. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.2 дугаар зүйл 1 дэх хэсэгт "Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ." гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Шийдвэр гүйцэтгэгч банк, эрх бүхий хуулийн этгээд дэх төлбөр төлөгчийн дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэр гаргаж, банк, эрх бүхий хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ." гэж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн хэрэгсэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, банк болон бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, тусгаарлахыг зохих байгууллагад даалгана." гэж тус тус заасны дагуу шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон прокурорын шийдвэрээр эд хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг холбогдох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлдэг.

Мөн 2019 онд Татварын ерөнхий хуулийг шинэчлэн найруулсан бөгөөд уг хуулийн 55 дугаар зүйлийн 55.2.4-т "хөрөнгө болон авлага битүүмжлэх" гэж, 60 дугаар зүйлийн 60.1-т "Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх гэснийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49.1-д заасан утгаар ойлгох бөгөөд барьцааны эрхгүй хөрөнгөөс эхлэн битүүмжлэх зарчим баримтална." гэж, тус тус заасны дагуу татварын албаны эрх бүхий албан тушаалтан хөрөнгө битүүмжлэх эрхтэй болсон.

1524022380

55

Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албанд аж ахуй нэгжийн дансыг битүүмжлэх эрх олгогдоогүй, харин Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй бол Санхүүгийн мэдээллийн албанаас тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар түр түдгэлзүүлэхээр хуульчилсан байдаг.

Түс албанаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу сүүлийн 10 жилийн хугацаанд түдгэлзүүлсэн гүйлгээний статистик, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт ... хуудастай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

58

Монголбанкны Ерөнхийдөгчийн 2024 оны
8 дугаар сарын 29-ны өдрийн А-11/680
дугаартай албан бичгийн хавсралт

Санхүүгийн мэдээллийн албаны шийдвэрээр түдгэлзүүлсэн гүйлгээний мэдээлэл

Огноо	СМА-ны шийдвэрээр гүйлгээ түдгэлзүүлсэн тоо /хуулийн этгээдийн тоогоор/	Гүйлгээ түдгэлзүүлсэн үндэслэл
2014	-	-
2015	-	-
2016	1	Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй
2017	-	-
2018	-	-
2019	1	Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй
2020	6	Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй
2021	3	Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй
2022	-	-
2023	1	Цахим мөрийтэй тоглоом зохион байгуулсан байж, мөнгө угаасан байж болзошгүй
2024	18	Хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоо нуун далдлах, мөнгө угаасан байж болзошгүй